



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2017 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/НЧ

Улаанбаатар хот

Эмнэлгийн тусламж үйлчилгээнд хяналт тавьж,
үйл ажиллагааг сайжруулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.1, Хөдөлмөрийн тухай хууль, Эрүүл мэндийн сайдын 2014 оны 180, 2013 оны 446 дугаар тушаалууд, Удирдлагын зөвлөлийн гишүүдийн хурлын шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллах зорилгоор ТУШААХ НЬ:

1. 2017 оны I улиралд эмнэлгийн тусламж үйлчилгээнд гарсан зөрчил дутагдалд дүгнэлт хийж клиникийн эмч, эрүүл мэндийн ажилтнуудад холбогдох хууль, тогтоол, эрүүл мэндийн сайдын тушаалууд, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод журам, ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа, ажил үүргийн хуваарийг дахин танилцуулан, ажлын хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор хяналт тавьж, сургалт зохион байгуулж, дадлагажуулан ажиллах албан тушаалтнуудын нэрсийг хавсралтаар баталж 2017 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн мөрдөн ажилласугай.

2. Энэ тушаалыг клиникийн эрхлэгч, үзлэгийн эмч нарт танилцуулж, биелэлтийг сар бүрийн сүүлийн долоо хоногийн Пүрэв гарагийн Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулж байхыг Эмчилгээ эрхэлсэн дэд захирал /О.Ганчулуун/-д үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Л.НАСАНЦЭНГЭЛ

000324

СЭМҮТ-ийн Ерөнхий захирлын
2017 оны 01 дугаар сарын 20-ны өдрийн
А/Ж дугаар тушаалын хавсралт



**Хяналт тавьж ажиллах албан тушаалтнуудын нэрс,
хариуцан ажиллах клиник**

| № | Овог, нэр | Албан тушаал | Хариуцан ажиллах клиник |
|---|---------------|-------------------------------------|-------------------------|
| 1 | О.Ганчулуун | Эмчилгээ эрхэлсэн дэд захирал | VI клиник, ХӨҮК |
| | О.Оюунтөгс | Сувилахуйн албаны дарга | |
| 2 | О.Баатаржав | СТХНХМТ эрхэлсэн дэд захирал | III клиник, |
| | Г.Уянга | Чанарын менежер | |
| 3 | В.Баярмаа | НЭМЭШСГХСТС эрхэлсэн дэд захирал | II клиник, Асрамж-1 |
| | М.Мөнгөнцэцэг | Чанар, стандарт хариуцсан арга зүйч | |
| 4 | Н.Оюунчимэг | Чанарын албаны дарга | IV клиник, ДЭСК |
| | Ж.Цэцэгмаа | Сувилгааны арга зүйч | |
| 5 | Д.Дэжидмаа | Поликлиникийн эрхлэгч | V клиник, ШСЭСК |
| | П.Бямбасүрэн | Сувилгааны арга зүйч | |
| 6 | Ш.Сугармаа | Хүний нөөцийн мэргэжилтэн | I клиник, Асрамж-2 |
| | М.Даваадулам | Хүний нөөцийн мэргэжилтэн | |